



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/09

Мандалговь

**Г Байгууллагын дотоод журамд нэмэлт, Г
өөрчлөлт оруулах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 130 дугаар зүйлийн 130.1, аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар бүлгийн 6.31.3-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/161 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журамд 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай. Үүнд:

1.1. Гуравдугаар бүлэгт “3.20.8. Жил бүрийн байгууллагын “Шинэ жилийн баяр”-аар 1-2 албан хаагчийг “Оны Азтан”-аар шалгаруулж, гадаад Улсад аялах эрхийн бичгээр шагнаж, урамшуулна.” гэсэн заалт нэмэх.

1.2. Гуравдугаар бүлгийн “3.21.11. Тамгын газрын ажилтныг тэтгэвэрт гарахад нь хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйл гардуулна” гэсэн хэсгийг “3.21.11. Тамгын газрын ажилтныг өндөр насны тэтгэвэрт гарахад нь хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйл гардуулах, гадаад оронд 7-10 хоног аялахад нь дэмжлэг үзүүлнэ” гэж өөрчлөх.

Хоёр. Дээрх нэмэлт, өөрчлөлтийг байгууллагын хуралд танилцуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-д, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын хэлтсийн удирдлагууд, нийт мэргэжилтэн, албан хаагчдад даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

488060052